

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ЗАХИРГАА ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БАЙЦААГЧ Б.ЦЭНГЭЛИЙН
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Нийгмийн даатгалын багц хуулийн болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, тайлагнах, зөвлөн туслах, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах”							
1.	Арга хэмжээ 1.1. Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг хангуулж аж ахуйн нэгж, байгууллага болон нийгмийн даатгалын байгууллагын дотоод үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх;	Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн байна.	Аж ахуйн нэгж, байгууллага болон нийгмийн даатгалын байгууллагын дотоод үйл ажиллагааг холбогдох журмын дагуу шалган хүлээлгэн өгсөн. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг үнэн зөв, хугацаандаа байршуулсан	Удирдамж гарган газрын даргаар батлуулах.	Хяналт шалгалтын удирдамжын дагуу Дадал, Норовлин, Галшар сумын 2024-2025 оны НДШ төлөлтийн тайлан, тооцоо, СДД-н гэрээ, үндэслэл, үндсэн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг шалгах, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголт, дотоод ажлын чиглэлээр хийж хэрэгжүүлж байгаа ажил, гарч байгаа алдаа зөрчлийг шалгасан. Шалгалтаар Норовлин сумын Онон улз ХХК, Галшар сумын Алтат ам ХХК-д нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.2-т заасны дагуу алданги тооцон төлбөр, зөрчлийг барагдуулан ажилласан. Ирсэн, явсан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт зэрэг бүртгэл хөтлөлтгүй, сайн дурын даатгуулагчийн гэрээг	2025.01.01-2025.06.30	100 78.5. 50.1

назартай хийсэн хяналт
мэргэжил хангагчийн

			эсэхэд тавих.	хяналт	дутуу хэвлэж баримтжуулаагүй зөрчил гарсан. Ажил олгогчийн цаасаар ирүүлсэн тайланг шалган үзэхэд шалгаж, хүлээн авсан хэсэгт нийгмийн даатгалын байцаагчийн гарын үсэг, тэмдэг, тэмдэглэгээ огт байхгүй байгаа нь маш том зөрчил гэж харагдаж байна. Дээрх зөрчил нь ирээдүйд гарч болзошгүй хуулийн этгээд, иргэний ямар нэгэн хууль эрх зүйн баримт бичгийн үндсэн баримт, нотолгоо зэрэгт хүчин төгөлдөр байх боломжгүй юм. Дадал сумын цэргийн ӨНТ авагч, ТАТ авагч нарын тэтгэврийн хувийн хэрэг алга болсон тул нөхөн бүрдүүлэхээр, цаашид алдаа дутагдал гаргахгүй байхад анхаарч ажиллах зэрэг үүрэг даалгавар өгч ажилласан. Мөн Нийгмийн даатгалын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэвэр авагчдын хувийн хэргийн тооллогын комиссыг хэрлэн суманд газрын даргын тушаалаар, сумдад сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж, тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэргийн тооллогыг 2025 оны 04 дүгээр сарын 08-10-ны өдрүүдэд зохион байгуулж тэтгэврийн хувийн хэргийн тооллогыг тэтгэвэр олголтын жагсаалттай тулган шалгасан. Шалгалтаар нийт тоологдвол зохих тэтгэврийн хувийн хэргээс тоологдсон 13924 үүнээс ӨНТ-11172, ХЧАТ-2054, ТАТ-692 тэтгэврийн хувийн хэрэг тоологдсон байна. Дутсан Дадал сумын 2, Баянхутаг сумын 1 тэтгэвэр авагчын хувийн хэрэг байна. Ж	
--	--	--	------------------	--------	---	--

2.	Арга хэмжээ 1.2. Хяналт шалгалтын хүрээнд зөвлөн туслах, хуулийг сурталчлан таниулах, илэрсэн төлбөр, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зэрэг ажлуудыг зохион байгуулах;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.	Хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг улирал тутамд гаргаж Хяналт, шалгалтын газарт хүргүүлсэн.	Хяналт шалгалтын хүрээнд зөвлөн туслах, хуулийг сурталчлан таниулах, илэрсэн төлбөр, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зэрэг ажлуудыг зохион байгуулах	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан даалгавар болон сургалт сурталчилгааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу НДЕХ-ийн шинэчилсэн найруулгыг цувралаар "Хэнтий мэдээ сонин"-той хамтран лайв, рийл, постер хэлбэрээр хүргэн ажиллаж байна. Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох хугацаа, Нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх сэдвээр хяналт шалгалтын хүрээнд хуулийг сурталчлан таниулж ажилласан байна. Мөн байгууллагын нягтлан бодогч нарт сургалт зохион байгуулан НДЕХ, Зөрчлийн тухай хуулийн заалт, авах арга хэмжээ, төлбөр зөрчлийг арилгах, нийтлэг алдааг дахин гаргахгүй байх зэрэг зөвлөгөө мэдээллийг хүргэн ажилласан. ✓	✓ 9 2025.01.01- 2025.06.30	100 ✓
3.	Арга хэмжээ 1.3. Хяналт шалгалтын дүнг нэгтгэн гаргах, цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулж танилцуулах;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.	Мэдээ, тайлан үнэн зөв гарсан байна	Тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэх	2025 оны хагас жилийн байдлаар гадаад болон дотоодын хяналт шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн оны эхний үлдэгдэл 111.5 сая төгрөг, шалгаж илрүүлсэн 30.9 сая төгрөг, нийт 142.4 сая төгрөгөөс 50.7 сая төгрөгийг барагдуулан 91.7 сая төгрөгийн төлбөр зөрчлийг барагдуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Тэтгэврийн тогтоолт, олголттой холбоотой илүү олгосон 29 тэтгэвэр авагчийн 83.3 сая төгрөг, Тэтгэмжийн тогтоолт олголттой холбоотой 28 даатгуулагчийн 7.0 сая төгрөг, үйл ажиллагааны зардлын зарцуулалттай холбоотой 1 даатгуулагчийн 0.4 сая төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт,	2025.01.01- 2025.06.30 9 Барагдуулсан нь 35% 8/сая.	100 ✓

					төлөлттэй холбоотой 1 байгууллагын 0.01 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр, 4 даатгуулагчийн 1.0 сая төгрөгийг нөхөн олгохоор байна. Нэгтгэсэн тайлангаас үзэхэд дээд шатны байгууллагаас илэрсэн төлбөр зөрчил нь 60.6 хувийг эзэлж байна. Хяналт шалгалтын дүнг нэгтгэн сумдын байцаагч болон Хэлтсийн дарга нарт танилцуулсан.		
4.	Арга хэмжээ 1.4. Эрх бүхий байгууллагын шийдвэр /улсын байцаагчийн акт/-ээр тогтоосон төлбөр, зөрчлийн барагдуулалтад хяналт тавих;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг улирал тутамд гаргаж Хяналт, шалгалтын газарт хүргүүлсэн.	Барагдуулалтад тухай бүр хяналт тавих	Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тухай бүр тооцон тайлан, мэдээг хугацаанд нь Хяналт шалгалтын газарт хүргүүлэн ажиллаж байна. 2025 оны хагас жилийн байдлаар дээд шатны болон хяналтын бусад байгууллагаас хийсэн шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн оны эхний үлдэгдэл 70.1 сая төгрөгөөс 14.5 сая төгрөгийг барагдуулан 55.6 сая төгрөгийг барагдуулах ажлыг зохион байгуулахаар байцаагч, ажилтнуудад үүрэг даалгавар өгч, хяналт тавин ажиллаж байна.	2025.01.01- 2025.06.30	100 78,5%
5.	Арга хэмжээ 1.5. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй эсвэл харьяаллын бус тохиолдолд шалгалтын акт, холбогдох баримт бичгийг эрх бүхий	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.	ХУД-т гэрээ байгуулсан сайн дурын даатгуулагч нь тус газарт нөхөн ногдуулалт хийхтэй холбоотой өргөдөл гаргаж, харьяалалын бус учир ХУД-ийн	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.	Хагас жилийн байдлаар гэмт хэргийн шинжтэй, харьяаллын бус зөрчил гараагүй байна.	2025.01.01- 2025.06.30	0 100%

	байгууллагад шилжүүлэх удирдах тушаалтанд танилцуулах, эсвэл албан		СДД-ын байцаагчтай холбогдон тодруулж, нөхөн төлөх боломжгүй гэсэн хариу хүргүүлж асуудлыг шийдвэрлэн ажилласан.				
6.	Арга хэмжээ 1.6. Хяналт шалгалтаар тогтоосон төлбөр, зөрчил нь хууль хяналтын байгууллага /шүүх/-аар шийдвэрлүүлэх тохиолдолд шүүх хуралдаанд төлөөлөн оролцох;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.	Хууль хяналтын байгууллага /шүүх/-аар шийдвэрлүүлэх төлбөр, зөрчил гараагүй болно.	Хяналт шалгалтаар тогтоосон төлбөр, зөрчил нь хууль хяналтын байгууллага /шүүх/-аар шийдвэрлүүлэх тохиолдолд шүүх хуралдаанд төлөөлөн оролцох	Энэ онд хяналт шалгалттай холбоотой зөрчил гараагүй боловч, өргөдөл гомдлын дагуу Өндөр насны тэтгэвэр авагч С.Шагдарсүрэнгийн нэхэмжлэлтэй Хэнтий аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдаанд удаа дараа тус газрыг төлөөлөн оролцсон. Шүүх хуралдаанаар нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, шүүхийн шийдвэр гарсан.	2025.01.01-2025.06.30	100 ✓
7.	Арга хэмжээ 1.7. Актаар тогтоосон өглөг, авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж холбогдох арга хэмжээг авч ажиллах;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.	Нийт 132.8 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс 83.07 сая төгрөгийг барагдуулан, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.	Актаар тогтоосон өглөг, авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж холбогдох арга хэмжээг авч ажиллах	Нийт 142.4 сая төгрөгөөс 50.7 сая төгрөгийг барагдуулан, 58 даатгуулагчийн 90.7 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр, 4 даатгуулагчийн 1.0 сая төгрөгийг нөхөн олгохоор холбогдох арга хэмжээг авч байцаагч болон Хэлтсийн дарга нарт үүрэг болгон ажиллаж байна.	2025.01.01-2025.06.30 35% барагдсан.	95 ✓
8.	Арга хэмжээ 1.8. Дээд газраас ирүүлсэн чиглэл, зөвлөмжийн хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын талаарх холбогдох мэдээ, тайланг тогтоосон хугацаанд нь үнэн зөв гаргаж хүргүүлэх.	Тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэсэн эсвэл үнэн мэдээлэл хүргэгдсэн байна.	Дээд газраас ирүүлсэн чиглэл, зөвлөмжийн хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын талаарх холбогдох мэдээ, тайланг тогтоосон хугацаанд нь үнэн	Тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэсэн эсвэл үнэн мэдээлэл хүргэгдсэн байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Хяналт шалгалтын газраас тус газарт НДЕХ, НДСОТТХ, НДСОТТХ, НДСОУОМШӨТТТХ-н хэрэгжилтийг 2018-2023 оны санхүүгийн болон холбогдох бусад баримтад хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах тухай 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн	2025.01.01-2025.06.30	100

			зөв гаргаж хүргүүлсэн байна.		32/00002 тоот улсын ахлах байцаагчийн албан шаардлагыг хүргүүлж цаашид алдаа зөрчил гаргахгүй байхад анхаарч хууль тогтоомжийг хэрэгжүүлэн албан шаардлагын биелэлтийг ханган ажилласан. 2025 оныг "Даатгуулагчийг дэмжих, Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах" жил болгон зарласан. Энэ зорилтын хүрээнд Нийгмийн даатгалын тогтолцоог олон нийтэд эергээр таниулж, мэдээ мэдээллийг хүртээмжтэй хүргэхээр Хэнтий мэдээ сонинтой хамтран ажиллаж байна. Хамтын ажиллагааны хүрээнд даатгуулагч, ажил олгогч нарт зориулсан мэдээлэл, зөвлөгөө, ярилцлага, нийтлэлийг цахим хуудсанд тогтмол байршуулан хандалтыг нэмэгдүүлж пэйж хуудсыг хөгжүүлэн мэдээ тайланг хүргүүлэн ажилласан.		
9.	Арга хэмжээ 1.9. Хяналт шалгалтын тайлан, мэдээ гаргаж, дээд шатны байгууллагад хүргүүлэх;	Тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэсэн эсвэл үнэн мэдээлэл хүргэгдсэн байна.	Мэдээ, тайлан үнэн зөв гарсан байна	Дотоодын хяналт, шалгалтын хагас жилийн тайланг үнэн зөв гаргаж баталгаажуулах, хуульд заасан хугацаанд дээд шатны байгууллагат хүргүүлсэн байна.	Хяналт, шалгалтын тайланг улирал бүр үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулах, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тухай бүр тооцон тайлан, мэдээг заасан хугацаанд Хяналт шалгалтын газарт хүргүүлэн ажиллаж байна.	2025.01.01- 2025.06.30	100
10.	Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн холбогдох	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт	Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу	Нийгмийн даатгалын газар нь Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай	2025.01.01- 2025.06.30	100

	заалтын хэрэгжилтийг хангуулж ажиллах;		заасны дагуу хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгон 100%-тай барагдуулан ажилласан.	хариуцлага тооцож, шийтгэлийн хуудсаар төлүүлэхээр шийдвэрлэсэн торгуулийг 100 хувь, шимтгэл, алдангийг 70-аас доошгүй хувиар барагдуулсан байна.	хуулийн дагуу тус газарт ирсэн гомдол мэдээллийг шалган тус хуульд заасан зүйл заалтын дагуу холбогдох арга хэмжээг авч зөрчилд хамаарах баримт материалыг прокурорын газраар хянуулан төлүүлэхээр шийдвэрлэсэн торгууль, шимтгэл, алдангийг тухай бүр барагдуулах ажлыг зохион байгуулан хуулийн хэрэгжилтийг ханган ажилладаг. 2025 оны хагас жилийн байдлаар Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгонд үйл ажиллагаа явуулдаг Ерөнхий боловсролын сургууль, Соёлын төв, Хүүхдийн цэцэрлэг, Амжилтын ташуур НҮТББ-тай холбоотой зөрчилд Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.1, 4.8 дугаар зүйлүүдийг тус тус удирдлага болгон холбогдогчоос мэдүүлэг авч, хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, тухайн ажил олгогч тус бүрийг Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 10.17.4-т заасны дагуу хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгон, нийт 1.0 сая төгрөгийн торгуулийг 100%-тай барагдуулан ажилласан.			
Зорилт 2. “Байгууллагын болон нэгжийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх, тайлагнах”								
1.	Арга хэмжээ Нэгжийн ажиллагааны зорилтыг хангахад чиглэсэн өөрийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах	2.1. үйл тогтоомжийн дагуу хийсэн байна.	Холбогдох хууль	Хагас, бүтэн жилээр гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан хуулийн хугацаанд гаргаж өгсөн.	Хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийсэн байна.	Захиргаа хяналтын хэлтэс нь 2025 онд хийх хяналт, шалгалтын төлөвлөгөө, удирдамж гарган газрын даргаар батлуулж, нийгмийн даатгалын тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар чиглэлийн дагуу дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн нэгжийн үйл ажиллагааны зорилтыг хангахад чиглэсэн	2025.01.01-2025.06.30	100

	хэрэгжилтийг хангаж ажиллах,				хяналт шалгалтын улсын байцаагчийн ажил байдлын тодорхойлолтод заасны дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж газрын даргаар батлуулсан байна.		
2.	Арга хэмжээ 2.2. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх зөрчил үүссэн тухай мэдэгдлийг тухай бүр гаргаж өгөх, тайлагнах,	Мэдэгдлийн тухай бүр гаргаж тайлагнасан байна.	Хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацаанд хөрөнгө орлогын мэдүүлгийг өгөөгүй болно.	Мэдэгдлийн тухай бүр гаргаж тайлагнасан байна.	Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг Авлигын эсрэг хууль, Хөрөнгө, орлогын мэдүүлгийн тухай хууль болон холбогдох ёс зүйн дүрэм, журамд нийцүүлэн хуульд заасан хугацаанд үнэн зөв, шинэчлэн 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор мэдүүлсэн.	2025.01.01-2025.06.30	100
3.	Арга хэмжээ 2.3. Нэгжийн чиг үүрэгтэй холбоотой мэдээ тайлан, судалгаа гаргах, танилцуулах;	Мэдээ, тайлан, судалгааг үнэн зөв, хугацаандаа гарсан байна.	Нэгжийн чиг үүрэгтэй холбоотой мэдээ тайлан, судалгааг тухай бүрт нь гаргаж, танилцуулсан.	Мэдээ, тайлан, судалгааг тухай бүр үнэн зөв, хугацаандаа гарсан байна.	Хэнтий аймгийн нийгмийн даатгалын газрын зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтны судалгаа, Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлд заасан "Нийгмийн даатгалын ерөнхий хууль зөрчих" зөрчлийг шалган шийдвэрлэсэн тоон мэдээлэл, Зөрчлийн хуулийн хэрэгжилтийн судалгаа, Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийн сургалтад хэнтий аймгийн нийгмийн даатгалын газраас хамрагдах эрх бүхий албан тушаалтны судалгаа, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч нар 2025 оны 04 дүгээр сарын 18-25 ны өдрүүдэд хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар нийгмийн	2025.01.01-2025.06.30	100

					даатгалын сангаас олгох ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлогын бүрдүүлэлт зарцуулалтад хийсэн хяналт шалгалтад холбоотой тайлан мэдээ, судалгааг гаргаж өгч ажилласан. Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны "Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай 03 дугаар албан даалгаврын хүрээнд Дотоод аудит мониторингийн газраас Шилэн дансны мэдээлэл байршуулалтад 2025 оны 01 дүгээр улирлын байдлаар хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар нийгмийн даатгалын сангийн нийт 43 мэдээллийг үнэн зөв хугацаанд нь байршуулж 100%-тай, үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт нийт 46 мэдээллийг үнэн зөв 100%-тай байршуулж, хугацаандаа мэдээлсэн 38, хугацаа хоцорсон 8 мэдээлэл байршуулж 83%-тай үнэлэгдсэн байна. 2025 оны хагас жилийн байдлаар нийгмийн даатгалын сангийн нийт 63 мэдээлэл байршуулахаас 63 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн, үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт нийт 67 мэдээлэл байршуулахаас 66 мэдээллийг хугацаандаа байршуулж, 1 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Шилэн дансанд байршуулсан мэдээлэлд хяналт тавин улирал бүр тайлан мэдээг Дотоод аудит мониторингийн газарт хүргүүлэн ажиллаж байна.		
4.	Арга хэмжээ 2.4. Албан хэрэг хөтлөлтийн талаарх	Холбогдох хууль тогтоомжийн дагуу	Хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацаанд архивд	1-р улиралд багтаан	Төрийн албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Архивын тухай хууль, Монгол Улсын Засгийн		

	хууль тогтоомж, баримт бичгийн стандартыг хэрэгжүүлж ажиллах, бүрдүүлсэн баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу жилийн эцэст архивд хүлээлгэн өгөх;	чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.	баримт хүлээлгэн өгөөгүй болно.		газрын тогтоолууд, холбогдох журам, заавар, Баримт бичиг хөтлөлтийн стандартад нийцүүлэн Улсын байцаагчийн акт, Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналт шалгалтын баримт, Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн материал, Сайн дурын залруулгын акт, Хяналт шалгалтын тайлан, Бүртгэл зэрэг баримтуудыг хуульд заасан хугацаанд архивд хүлээлгэн өгсөн.	2025.01.01- 2025.06.30 <i>найрзуулга хууль</i>	100 93.
5.	Арга хэмжээ 2.5. Иргэд, ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах,	Өргөдөл, санал, гомдлыг хууль тогтоомжийн дагуу хугацаанд шийдвэрлэсэн байна.	Иргэд, ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг тухай бүрт нь шийдвэрлэж ажилласан.	Хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь шийдвэрлэсэн байна.	Хагас жилийн байдлаар нийт 74 даатгуулагчтай холбоотой өргөдөл гомдол ирснээс албан журмын даатгуулагчийн хууль бусаар ажлаас халагдсан, ЦХТАО, даатгуулагчийн төрөл, ажил мэргэжлийн код, үндсэн мэдээллийг буруу тайлагнасан, хүүхэд асрах чөлөөтэй байх хугацааны шимтгэлийг төлөөгүй орхигдуулсан, ээлжийн амралтын цалинг нийт дүнгээр тайлагнасан, жирэмсэн амаржсаны тэтгэмжийн мөнгөн дүнгээр нийгмийн даатгалын шимтгэлийг буруу тайлагнасан, овог нэр регистрийн дугаарыг андуурч өөр даатгуулагч дээр шимтгэл төлөгдсөн гэх мэт зөрчлүүдтэй холбоотойгоор даатгуулагчийн ирүүлсэн өргөдөл, шүүхийн шийдвэр, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт, эмнэлгийн хуудас, цалингийн хүснэгт, тушаал зэрэг холбогдох баримт материалыг шалган үзэж 16 байгууллагын 18 даатгуулагчид Улсын байцаагчийн акт үйлдэн нөхөн оруулж, 9	2025.01.01- 2025.06.30 <i>хугацааны нийгмийн даатгал</i>	100 C

					байгууллагын 11 даатгуулагчийн цалин, төрлийн залруулга, ажил мэргэжлийн код, үндсэн мэдээллийг тухайн сар болгон дээр залруулан шийдвэрлэсэн байна. Мөн СДД-д хамрагдах гэрээ байгуулан шимтгэл төлж байх хугацаандаа байгууллагат ажиллан цалин авч, нийгмийн даатгалын шимтгэл давхар төлөгдсөн 34 даатгуулагчийн СДД-н цалинг тэглэн, дараа сард шилжүүлэн тооцох, төлсөн шимтгэлийг буцаан олгох тухай СДД-н шимтгэл төлөлтийг залруулах акт үйлдэн засварлан ажилласан байна. ГБХНХ яаманд гаргасан өргөдлийн дагуу ӨНТ авагчийн цалингийн үндэслэлийг шалган өөрчлөн тогтоох боломжтой гэж үзэн тэтгэвэрт өөрчлөлт оруулан, дахин тогтоосон байна. 1 даатгуулагчийн өргөдлийг шалган үзээд шимтгэлийг нөхөн тооцох боломжгүй тухай, 10 даатгуулагчийн СДД, тэтгэмжийн тогтоолт олголт, НДШ төлөлт, нөхөн төлүүлэх, тэтгэврийн үндэслэл, Иргэд, олон нийттэй харилцах төвд гаргасан гомдлын дагуу хариуг тухай бүр албан тоотоор хүргүүлэн ажилласан байна.		
--	--	--	--	--	--	--	--

6.	Арга хэмжээ 2.6. Удирдлагын даалгавраар ажил үүрэг гүйцэтгэх, танилцуулах, шаардлагатай тохиолдолд ажил орлон гүйцэтгэх;	Тухай бүр гүйцэтгэж, шаардлагатай тохиолдолд ажил орлон гүйцэтгэсэн байна.	Удирдлагын өгсөн үүрэг даалгаврын дагуу тухай бүр ажил гүйцэтгэж, танилцуулж, шаардлагатай тохиолдолд ажил орлон гүйцэтгэж ажилласан.	Тухай бүр удирдлагын өгсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэж, шаардлагатай тохиолдолд ажил орлон гүйцэтгэсэн ажилласан байна.	2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Б/20 тоот тушаалаар Тэтгэвэр, тэтгэмжийн хяналт шалгалтын байцаагчаар ажил хавсран гүйцэтгэж, тэтгэмжийн тогтоолт олголттой холбоотой 508 даатгуулагчийн материал, 165 тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэрэг болон холбогдох материалыг хянан шалгасан байна. Тус газрын дэргэдэх Залуучуудын зөвлөлийн хүрээнд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр биелүүлэн ажиллаж байна. Мөн удирдлагаас өгсөн чиг үүргийн дагуу 2024 оны жилийн эцсийн тэтгэврийн тайлан гаргалтад оролцон ажилласан байна.	2025.01.01- 2025.06.30	100 ✓
7.	Арга хэмжээ 2.7. Хөдөлмөрийн дотоод журам үйл ажиллагааны хүрээнд гарсан бусад дүрэм журам, зааврыг мөрдөж ажиллах;	Дүрэм, журам, зааврыг мөрдөж ажилласан байна.	Хөдөлмөрийн дотоод журам үйл ажиллагааны хүрээнд гарсан бусад дүрэм журам, зааврыг мөрдөж ажилласан.	Дүрэм журам, зааврыг мөрдөж ажилласан байна.	Хөдөлмөрийн дотоод журам үйл ажиллагааны хүрээнд гарсан бусад дүрэм журам, заавартай тухай бүр танилцан, өдөр тутамдаа мөрдлөг болгон ажиллаж байна.	2025.01.01- 2025.06.30	100 ✓
8.	Арга хэмжээ 2.8. Олон нийтийн арга хэмжээнд оролцох, зохион байгуулах;	Зохион байгуулагдсан ажилд идэвхтэй оролцсон байна.	Олон нийтийн арга хэмжээ, нээлттэй хаалганы өдөрлөг болон сургалтыг зохион байгуулах ажлуудыг тухай бүр хийж гүйцэтгэсэн.	Зохион байгуулагдсан ажилд тухай бүр идэвхтэй оролцсон байна.	Баянхутаг сумын малчдын зөвлөгөөнд Магадлагч эмч Д.Долгоржав, Хяналт шалгалтын байцаагч миний бие иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэж мэдээлэл өгч ажилласан нь сумын малчин иргэдийн сэтгэлд хүрсэн ажил болж өндөрлөсөн. "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал" зүүн бүсийн зөвлөгөөн 2025 оны 05 дугаар сарын 02-03-ний өдрүүдэд зохион байгуулагдаж тус газрын албан хаагч ажилчид бүртгэл хөтлөлт болон зөвлөгөөнд төлөөлөн оролцсон. Мөн ахмад настны тухай хууль, Засгийн газрын шийдвэр, бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор Хэнтий	2025.01.01- 2025.06.30	100 ✓

					аймгийн ахмадын хорооноос ирүүлсэн удирдамжийн дагуу "Ахмадаа дээдэлъе" өдөрлөгийг 2025 оны 05 дугаар сарын 26-ний өдөр 317 ахмад настан оролцож "МУГЖ Намдагийн Төмөрхуягийн нэрэмжит Хэрлэн сумын Соёлын төв"-тэй хамтран өдөрлөгийг амжилттай зохион байгуулсан.		
Биелэлт 99.7 хувь							
Нийт үнэлгээ 99.7 %							

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрсэн түвшин		Эхлэх, дуусах хугацаа	Биелэлт ийн хувь
				Хүрэх түвшин	Хүрсэн түвшин/биелэлт/		
	1	2	3	4	5	6	7
1.	НДЕГазар, НДГазар болон орон нутгийн засаг захиргаанаас зохион байгуулсан сургалтанд хамрагдах	Мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.	НДЕГазар, НДГазар болон орон нутгийн засаг захиргаанаас зохион байгуулсан сургалтуудад тухай бүр хамрагдсан	Хууль тогтоомжийн өөрчлөлттэй танилцах. Ажилдаа хэрэгжүүлж ажиллах өөрийгөө хөгжүүлэх	"Нэг цаг Нэмэх цэнэг" төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтаар "Захиргааны шийдвэр гаргах ажиллагаа" захиргааны акт, "Стресс менежмент", "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, орон нутагт ажиллаж амьдрах эрхийн баталгааг хангахад анхаарах асуудлыг тодорхойлох", Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Мод түүний ач холбогдол зэрэг сэдвээр Хэнтий аймгийн ЗДТГ болон ТА3-с цахим сургалт, Илүү төлсөн шимтгэл буцаан олгох тухай сургалт, НДЕГ-с 7 хоног бүрийн 5 дахь өдөр зохион байгуулсан Мэдээллийн цаг сургалтаар илүү төлсөн шимтгэлийг буцаах журам, НДШ төлөгчид бүртгэлийн дугаар олгох, хэрэглэх болон хувийн хэрэг нээх, бүртгэл хөтлөх, шилжүүлэх журам, НД-д сайн	2025.01.01-2025.06.30	100

					дураар даатгуулахад баримтлах журам, НДШ-ийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам, итгэлцүүр хэрэглэх журам, нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх журам, мөн газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалтыг хэрэглэх журам, Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичиг, тэтгэвэр олгох журам, Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил мэргэжлийн жишиг цалин, Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох тухай тогтоол журмуудын талаар мэдээлэл хүргэсэн. Мөн албан хаагчдын нийгмийн даатгалын мэдээллийн SICOS системийн талаар нэгдсэн ойлголттой болох нийгмийн даатгалын албан хаагчдын чадавхжуулах, Авлагыг барагдуулах авлагын менежментийн сургалтуудад хамрагдсан.		
2.	Монгол бичгийн чадварт суралцах	Үндэсний бичиг соёлоо мэддэг, уншиж бичих чадвартай болсон байх	Сургалтанд хамрагдсан.	Унших чадвар сайжирсан байх. Сургалтанд хамрагдах.	Үндэсний бичгээр баримт боловсруулах арга зүй сэдэвт сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 19-ны өдөр НДЕГ-с цахимаар зохион байгуулсан.	2025.01.01-2025.06.30	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧ

(Албан тушаал)

..... /Б.ЦЭНГЭЛ/

(Нэр, гарын үсэг)

2025 06 04

(Огноо)